



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/106

Улаанбаатар хот

Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд
хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
албан хаагчийг томилох тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт, Улсын Их Хурлын 2024 оны “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 27 дугаар тогтоолын 2, хөтөлбөрийн 3.1.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хилийн боомт, орон нутаг дахь нэгжид ажиллах байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээлэл солилцох, уялдаа холбоо, зохицуулалтыг хангах, тайлагнах чиг үүрэг бүхий албан хаагчдыг хавсралтад зааснаар томилсугай.

2.Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажил, арга хэмжээг төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмэлт ажлаар тусган хэрэгжилтийг хангаж ажиллахыг (Б.Цэгмид, П.Гантулга, Э.Шинэтуяа, Т.Баяржаргал, Б.Батцэцэг, Х.Хэрлэн-Урсгал, С.Гүлбану) нарт үүрэг болгосугай.

3.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хүрээнд холбогдох албан хаагчдыг мэргэшил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангаж ажиллахыг байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо (Н.Дуламсүрэн), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (И.Баатархүү)- т тус тус даалгасугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын
2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн
11/06 дугаар тушаалын хавсралт

ХИЛИЙН БООМТ, ОРОН НУТАГ ДАХЬ НЭГЖИД АЖИЛЛУУЛАХ
БАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АЛБАН ХААГЧИД

№	Нэгж, албан тушаалын нэр	Албан хаагчийн овог, нэр
1	Агаарын замын боомт хариуцсан газар, хяналтын улсын байцаагч	Болдын Цэгмид
2	Дорноговь аймаг дахь газар, ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч	Пүрэвдоогийн Гантулга
3	Өмнөд бүс дэх газар, хяналтын улсын байцаагч	Эрдэнийн Шинэтуяа
4	Баруун бүс дэх газар, Говь-Алтай аймаг дахь ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч	Тунгалагийг Баяржаргал
5	Хойд бүс дэх газар, ээлжийн ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч	Баярмагнайн Батцэцэг
6	Зүүн бүс дэх газар, төсөв, санхүү хариуцсан ахлах мэргэжилтэн	Хуягбаатарын Хэрлэн-Урсгал
7	Баян-Өлгий аймаг дахь хэлтэс, хяналтын улсын байцаагч	Сонгыбайн Гүлбану

---oOo---